



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Чөлөөт бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн 8.7.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.7.11.чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх, тамхи худалдах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу олгох.

**2 дугаар зүйл.** Чөлөөт бүсийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” гэснийг “Зөвшөөрлийн тухай” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Чөлөөт бүсийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “, лиценз” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР